

**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын
Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл /2013-12-13/**

Ажлын хэсгийн 34 дугаар хуралдаан 2013 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 10 цагт Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн хурлын танхимд зохиогдов.

Ажлын хэсгийн хуралдаанд Уул уурхайн яамны БХЗГ-ын мэргэжилтэн Б.Хулан, Ашигт малтмалын газрын Нөөц, судалгааны тасгийн дарга Б.Бямбадагва, мэргэжилтэн Д.Мөнхсайхан, Татварын ерөнхий газрын татварын байцаагч Д.Энхтуяа, Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Н.Алгаа, Хил хязгааргүй алхам ТББ-ын тэргүүн Н.Баярсайхан, МБОИЗ-ийн удирдах зөвлөлийн гишүүн Б.Батболд, МБОИЗ-ийн удирдах зөвлөлийн гишүүн Ж.Гомбожав, Ил тод сан ТББ-ын ажилтан Т.Отгонсүрэн, Хөвсгөл далайн эзэд сангийн тэргүүн Б.Баярмаа, Хүний эрх хөгжлийн төвийн ажилтан Н.Байгалмаа, Оюутолгой ХХК-ны Олон талт хамтын ажиллагааны мэргэжилтэн О.Адъяа, Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон нар оролцов.

Мөн Засгийн газрын ахлах референт Э.Сумъяа, Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын мэргэжилтэн Г.Зулай, Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн Б.Мөнхбат, Миний Монголын газар шороо хөдөлгөөний тэргүүн С.Отгонсайхан, Хариуцлагатай уул уурхайн санаачилга ТББ-ын тэргүүн Л.Долгормаа нар бичгээр саналаа ирүүлж, хуралд ирснээр бүртгүүлэх хүсэлт гаргасныг хэлэлцэн, ирснээр тооцох болов.

Хуралд ажлын хэсгийн 33 гишүүнээс 17 гишүүн оролцож ирц 51,5 хувьтай байв.

Хуралдаанд Адам Смит байгууллагын менежер П.Оюунбилэг, Интерконсалтинг компанийн судалгааны багийнхан болон ажлын албаны харилцааны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа, санхүүгийн ажилтан А.Отгонтунгалаг нар оролцов.

Хурлыг Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Н.Алгаа удирдан явуулав.

Н.Алгаа: Өнөөдрийн хурлыг би удиран явуулах болно. Хуралд ирвэл зохих 33 хүнээс 17 хүн ирсэн бөгөөд ирц 51,5 хувьтай байгаа тул хурлаа эхлэх саналтай байна. Ингээд хурлын хэлэлцэх асуудал болон дотоод журмыг танилцуулъя.

Хурлын дотоод журамд танилцуулга хүн бүр 30 минут гэснийг 20 минут болгох саналтай байна. Гишүүд дэмжив.

I. ХЭЛЭЛЦСЭН нь: Нийслэл аймаг сумын ОУИТБС-ын дэд зөвлөлийн ажиллах журмын төсөл

Н.Алгаа: Дэд журмын төслийг ТАН эвслийн зохицуулагч Н.Баярсайхан танилцуулна.

Н.Баярсайхан: За баярлалаа. Ингээд танилцуулга хийхийн өмнө бидний хийсэн мониторингийн талаар мэдээлэл өгөхийг хүсэж байна. (Судалгааг хавсаргав). Дараагийн танилцуулга маань дэд зөвлөлийн журмын төсөл юм. Үүнийг та бүхэнд тараасан байгаа. Уншиж танилцсан байх. Журамд өөрчлөлт оруулахдаа бүсийн семинарын үеэр хөдөө орон нутгийн оролцогчдоос гарсан саналыг тусгахыг зорьсон байгаа. (Танилцуулга болон журмын төслийг хавсаргав)

Б.Дэлгэрмаа: Дэд зөвлөлийн журмын төслөө орон нутагт болсон сургалт, семинар дээр хүмүүст тарааж санал авсан байгаа. Үүний дагуу саналуудыг аль болохоор журамд тусгахыг зорьсон байгаа. Ингээд та бүхнээс энэ журам дээр санал авахыг хүсэж байна.

Н.Баярсайхан: Гэхдээ санал болон орох боломжгүй юм. Үндсэн санааг нь оруулаад хөнгөхөн журамтай болох хэрэгтэй байна.

Н.Алгаа: Ер нь та бүхэнд журмын төсөл тараачихсан байгаа юм байна. Гэхдээ бид энэ талаар сайн ярьж чадсангүй. Голчлон судалгааны танилцуулгыг сонслоо. Тиймээс дэд зөвлөл нь ямар бүтэцтэй байхаа тохиролцоогүй байхад дэд зөвлөлийн журмын төслийг хэлэлцэж батлах нь учир дутагдалтай юм. Тэгэхдээ бид процедурын хувьд ажлын хэсгээр хэлэлцээд, дараа нь Үндэсний зөвлөлд оруулах хэрэгтэй тиймээс та бүхэн журмын төсөлтэй холбоотой асуулт байвал асууж болно. Дараа нь санал хэлэх боломжтой.

Ж.Гомбожав: Дэд зөвлөл аймаг сум дүүрэгт байхаар байна уу. Бид бүсийн семинараар аймагт дэд зөвлөлтэй, сумдад салбар зөвлөлтэй байя гэж ярилцаж байсан. Тэр санал хүлээж авахгүй байна уу эсвэл холилдоод байна уу?

Б.Бямбадагва: Дэд зөвлөлийн журамд Засаг даргын тамгын газар санхүүжилтийг хариуцна гэж оруулсан байна. Энэ ямар асуудлыг шийдвэрлэх зорилгоор ямар хэмжээний зардлыг оруулж байгаа юм бол?

Н.Баярсайхан: Дэд зөвлөл нь төсвөө гаргаад Засаг даргадаа танилцуулаад, Засаг дарга нь ИТХ-аар уг төсвөө батлуулна гэсэн үг. Төрөөс санхүүжүүлэх нь илүү үр дүнтэй байх гэсэн санал гарч байсан. Мөн ажлын албанаас томоохон санхүүжилт аваад Дэд зөвлөлийн нарийн бичгийн дарга нараа урамшуулаад явах боломжтой гэсэн санал ч гарч байсан. Гэхдээ энэ одоогоор боломжгүй юм.

Б.Батболд: Компанийн төлөөлөл гээд мэргэжлийн холбоод үйлдвэрчний эвлэл гэж орсон байна. Энэ чинь бас л төрийн бус байгууллага шүү дээ. Тэгэхээр ҮЭ-үүд нь иргэн талдаа орох ёстой байх.

Н.Баярсайхан: Тийм байна. Үүнийг анхааръя.

Б.Баярмаа: Дэд зөвлөл тарах, дахин зохион байгуулагдах зэрэг асуудал гарвал түүнийг зохицуулах зохицуулалт ороогүй байна. Үүнийг оруулах нь хэрэгтэй юм бишүү. Тухайлбал маргаан гарах зэрэг...

Н.Баярсайхан: Хамтран ажиллах санамж бичиг байгуулна гэж үзэж байгаа. Үүгээрээ нилээд асуудлыг тохиролцоно. Тухайн төлөөлөл өөрсдийн хүмүүсээ томилж оруулна гэж оруулсан байгаа.

Б.Баярмаа: Маргаан үүсэхэд санамж бичиг чинь эрхзүйн акт болж чадах уу.

Б.Дэлгэрмаа: Ямар нэгэн маргаан үүсэхэд талууд ямар үүрэг хариуцлага хүлээх вэ гэдэг талаар тусгах нь зүйтэй юм байна. Одоогоор энэ талаар оруулаагүй байгаа.

Ш.Цолмон: Төрийн бус байгууллагуудын хуулиар ч юм уу ямар нэг хуулийн заалтаар зохицуулахаар оруулж болох уу.

Б.Баярмаа: Болно. Ямар нэгэн зохицуулалт л оруулах өгөх хэрэгтэй.

Н.Алгаа: За асуулт дууссан бол санал хэлж болно.

Б.Батболд: Журмын 8 дээр төлөөлөх төлөөллийн тоог тогтооно гэсэн байна. Энэ юу гэсэн үг вэ?

Б.Дэлгэрмаа: Тэнцүү төлөөллөөр гээд дээр нь байгаа.

Б.Батболд: Тэгвэл энэ чинь давхардаад байна. Угаасаа тал бүрээс 3 хүн байна гээд заачихсан байхад ингэж оруулах нь буруу юм.

Н.Алгаа: Орон нутагт янз янз байж болно. Төрийн төлөөлөл хэд байна тэр тоогоор бусад талуудын төлөөллийг тогтооно гэж ойлгогдож байна.

Б.Батболд: ... “байгууллага, компани, иргэн тэнцүү төлөөллөөс бүтсэн” гэж байна.

Б.Дэлгэрмаа: Энэ бол ерөнхий бүх төлөөлөл тэнцүү байна гэдгийг тусгасан юм. Засаг дарга эхлээд төлөөллөө тогтоосны дараа түүнтэй тэнцүү тооны төлөөлөл бусад талуудаас орно гэсэн утгатай.

Н.Алгаа: Заавал үүнийг хасах гээд яах вэ?

Н.Баярсайхан: Найруулаад оруулчихъя.

Б.Батболд: “...томилж түүнтэй тэнцүү тооны тус тусын төлөөлөлийг оруулна” гэж оруулъя.

Гишүүд: Болж байна. Зүйтэй санал байна.

Ж.Гомбожав: Журмын 6 дээр төлөөлөлийг ИТХ-аар байгуулна гэсэн байна. Засаг дарга бол тоог тогтоох шаардлага байхгүй харин төрийн төлөөллийн тоог тогтоох хэрэгтэй. Журмын 6 болон 8 дугаар заалт чинь зөрчилдөөд байна. Мөн нутгийн захиргаанаас хараат бус нэгдсэн хурал гэдэг нэр томъёо ямар ч хууль дүрэмд байхгүй. Үүнийг сум, аймагт иргэдийн хурал, баг дээр бол багын нийтийн хурал гэж томъёолох нь зүйтэй болов уу. Мөн 9,2 болон 10,2 заалтууд давхардсан байна. Үүнийг нэг томъёололтой болгох. Ер нь томъёололын хувьд соёлгүй, хууль зүйн мэдлэг муутай томъёолууд орсон байна. Зарчмын хувьд аймаг, сумын ИТХ дэд зөвлөлийг байгуулаад зөвлөлийн үйл ажиллагааг баг, сум, аймгийн иргэдэд тайлагнадаг байх, зөвлөлийн гурван талын төлөөллүүд өөр өөрийн байгууллагадаа мөн тайлагнадаг байх нь зөв юм. Аймаг, нийслэлдээ дэд зөвлөлтэй, сум багт салбар зөвлөлтэй байхаар тогтох хэрэгтэй байна. Тэгээд тус тусын удирдлагаар, мэдээллээр хангадаг байх нь зөв юм. Мөн чиг үүрэг нь

тодорхой, ойлгомжтой байх хэрэгтэй байна. Энэ чинь дэд зөвлөлийн тоглоомын дүрэм гэсэн үг шүү дээ. Иймээс аймаг, нийслэл, сум, баг ямар үүрэгтэй яаж ажиллах вэ гэдгийг нь товчхон тодорхой болгох хэрэгтэй байна. Одоо энэ журмын төслөө жаахан боловсруулаад янзалчихвал болох юм. Өөрөөр хэлбэл дэд зөвлөлийн тоглоомын дүрмийг тодорхой болгох хэрэгтэй байна. Төвийн болон Дарханы семинар дээр төлөөлөгчдөөс гаргасан тодорхой саналуудыг журамдаа тусгаж өгөх хэрэгтэй байна.

Б.Баярмаа: Дэд зөвлөл маань дүрэмтэй юу. Журмын бүтцийг хараад байхад дүрмийн бүтэц харагдаад байна. Хэрвээ дүрэмгүй юмыг журамлах гээд байгаа бол бүр тодорхой нарийвчлах шаардлагатай байна. ТББ бол дүрэмтэй байдаг, тэгээд дүрмээ журамладаг. Жишээлбэл дэд зөвлөлийн санхүүжилтийг яаж зарцуулах юм, яах тайлагнах вэ, хариуцлага нь ямар байх вэ гэх мэтчилэнгийн маш тодорхой зохицуулалтгүй явбал мониторингийн дүн бас л тодорхойгүй үлдэх гээд байна. Энэ журам юм бол үйл ажиллагааны хэлбэр заагдахгүй байх жишээтэй. Ер нь дүрмээр нилээд ерөнхий зохицуулалтыг тусгадаг бөгөөд журмаар асуудлуудаа нарийвчлаад явдаг аргачлал бас байдаг. Эсвэл дүрэмгүй тохиолдолд журмаа нарийвчлахгүй бол хэрэгжүүлэхэд ойлгомжгүй учир дутагдалтай болох байх. Тухайлбал, хуралдааны шийдвэрийг ямар тохиолдолд хүчинтэй хүчингүй гэж тооцох вэ, яаж албажуулах вэ, цаашилбал шийдвэрийн хэрэгжилтийг хэн хянах вэ, ажлаа хэнд тайлагнах вэ гэх мэтчилэн асуудлуудыг зохицуулах хэрэгтэй.

Н.Алгаа: За өөр санал байна уу.

Б.Бямбадагва: Дэд зөвлөл нь ажлын албатайгаа яаж холбогдож ажиллах вэ? Санхүүжилтээ орон нутгаас авчихна, төлөвлөгөөгөө иргэдийн хурлаар батлуулахаар тусгасан өөрөөр хэлбэл бүх юмнууд нь орон нутагт төвлөрөхөөр журамд тусгасан байна. Одоогийн ажиллаж байгаа шигээ гурван талын тэгш оролцоог хангах талаар тусгах нь зүйтэй болов уу. Тухайлбал, ажлын албанаас сургалт семинар зохион байгуулахад дэд зөвлөлтэйгээ яаж уялдах вэ гэх мэтчилэн.

Н.Алгаа: Журмын төсөлд тусгасан зүйлүүд сайтар уншиж танилцаад гишүүд бичгээр санал өгөх нь зүйтэй юм. Бүсийн семинарын үеэр тохирсоны дагуу аймаг, нийслэл нь салбар зөвлөлтэй, цаашлаад дэд зөвлөлтэй байх гэхдээ дэд зөвлөл нь шаардлагатай сумдад нь байгуулах гэдгээрээ тогтох нь зүйтэй байх. Тодорхой гарцуудыг зааж өгөөд бичгээр дахин санал аваад дахин бичгээр тараагаад дараа нь Үндэсний зөвлөлд оруулах нь зүйтэй байна.

Ш.Цолмон: Ер нь хугацааны хувьд маш шахуу байгаа. Тэгэхээр саналаа яаралтай явуулах хэрэгтэй байх.

Н.Баярсайхан: Та бүхний хэлсэн саналууд нилээд туссан байгаа хэлсэн үг бүрээрээ тусах боломжгүй юм. Ерөнхий утгаараа тусах байх. Гишүүд саналаа аль болох яаралтай явуулвал сайн байна. Мөн хурлын хэлэлцэх асуудалд мониторингийн дүнг танилцуулах, дэд зөвлөлийн дүрэм танилцуулах гэж оруулаагүйгээс цагтаа багтсангүй. Мониторингийн дүнг танилцуулахгүйгээр журмын төслийн танилцуулах боломжгүй юм. Мөн дараагийн хэлэлцэх асуудал бас л мониторингийн дүнгээ танилцуулна. Дараа нь судалгааны үр дүнг танилцуулах байгаа. Та бүхэн сайн уншиж байгаад саналаа өгөөрэй.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Ажлын хэсгийн гишүүдийн бичгээр болон хурлын үед гаргасан саналыг 2013 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 15 цагаас өмнө хүлээн авч нэгтгэн боловсруулаад Үндэсний зөвлөлд танилцуулахыг ТАН эвслийн зохицуулагч Н.Баярсайхан, ажлын албаны харилцааны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа нарт даалгав.

ХЭЛЭЛЦСЭН нь: Монголын ОУИТБС-ын Үндэсний тайлангуудаар өгсөн дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилт

Н.Алгаа: Одоо хоёрдугаар асуудлыг Хүний эрх хөгжил төвийн ажилтан Н.Байгалмаа танилцуулна. Танилцуулгыг 20 минутад багтаан хийхээр тохирсон байгаа.

Н.Байгалмаа: Ажлын хэсгийн гишүүдээс уучлалт хүсье. Бид судалгааны материалуудаа аваад хэрэгжсэн, хэрэгжээгүйгээр нь ангилсан боловч зарим төрийн байгууллагын хүмүүстэйгээ уулзаж амжаагүй байгаа тул 100 хувь дүгнэлт нь гараагүй байгаа юм. Гэхдээ судалгаа яаж явагдаж байна вэ гэдгээр мэдээлэл авахыг хүсвэл одоо таницуулж болох юм.

Н.Баярсайхан: Тэгвэл дүн нь гараагүй гэсэн үг байна.

Гишүүд: Судалгааны дүгнэлт нь гараагүй, дутуу байгаа асуудлыг яриад яах вэ? Хойшлуулах нь зөв байх.

Н.Алгаа: Энэ асуудлыг одоогийн Үндэсний зөвлөлийн хуралдаанаар оруулах гэж шахаж дутуу юм хийлгэж байснаас он гараад Үндэсний зөвлөлийн ээлжит бус хурал хуралдуулаад танилцуулж болно шүү дээ. Одоо болох хурлаараа аудитын тайлан болон 2014 оны төлөвлөгөө зэрэг асуудлуудаа хэлэлцүүлвэл дээр байх.

Н.Алгаа: За тэгвэл энэ асуудлыг дараагийн хуралдаанд оруулахаар шийдвэрийн төсөлд оруулаад гуравдугаар асуудалдаа орох уу. Бид асуудлаа сайн боловсруулаад ээлжит бус хуралд танилцуулахаар шийдэх үү.

Гишүүд зөвшөөрөв.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Судалгаа дуусаагүй учраас үүнийг судалгаа дууссаны дараа ажлын хэсгийн хурлаар дахин хэлэлцэхээр хойшлуулав.

III. ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын ОУИТБС-ын олон нийтийн харилцааны өнөөгийн байдлын талаар Интерконсалтинг групп компанийн хийсэн судалгааны дүн

Н.Алгаа: Дараагийн танилцуулгыг Сэлэнгээ хийнэ. Журмын дагуу асуудлыг 20 минутанд багтаах хэрэгтэй

П.Оюунбилэг: Сайн байцгаана уу. Манай төслийн хүрээнд ажлын албаны коммуникацийн хүрээнд судалгаа хийх, үйл ажиллагааг нь шинэчлэх үүрэгтэй байгаа. Үүний хүрээнд Интерконсалтинг зөвлөх компанийн захирал Энхжаргал,

зөвлөх Сэлэнгээ болон багын бусад зөвлөхүүд ажиллаж байгаа. Энэ ажлын үр дүнд ОУИТБС-ын коммуникацийн шинэ ажлын хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөө гарах юм. Одоогийн байгаа төлөвлөгөө маань маш дэлгэрэнгүй, ямар мэдээллийг хэнд ямар аргаар хүргэх зэрэг нь маш тодорхойгүй байгаа. Үүнийг бид маш нарийвчлах, зорилгод бүлгүүдээс аль нь хамгийн чухал юм, ямар мэдээллийг илүү өгөх вэ гэдгийг тодорхой болгох зорилготой юм. Иймээс бидний ажил хязгаарлагдмал буюу зөвхөн коммуникаци дээр чиглэсэн байгаа. Энэ ажлын хүрээнд 2 төрлийн судалгаа хийсэн. Үүнд нэгдүгээрт бүлгийн ярилцлага, нөгөө нь хувьчилсан ярилцлага юм. Бид түрүүний уулзалтаас бүлгийн ярилцлагын үр дүнг танилцуулсан бол өнөөдөр хувьчилсан ярилцлагын үр дүнг танилцуулах бөгөөд ямар нэгэн шийдвэр гарахгүй, та бүхний саналыг сонсоно. Дараагийн уулзалтаар шийдвэр гаргах үйл ажиллагаа явагдана.

Ш.Сэлэнгэ: Би танилцуулгын өмнөөс 2 зүйлийг хэлье. Энэ судалгаа маань шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хийгдсэн бөгөөд цаашдаа хэрэг болохуйц бичиг баримт болох талаас нь хараарай. Судалгаа маань өнөөдрийн нөхцөл байдалд ямар ололт байна, цаашид ямар үр дүнд хүрэх талаар дүгнэлт гарах ёстой. Энэ судалгаа нь статистик тоогоор буюу жигнэсэн дундаж аргаар хийгдсэн байгаа. (Судалгааны танилцуулгыг хавсаргав)

Н.Алгаа: Судалгааны талаар асуулт байна уу

Б.Баярмаа: Энэ хоёр судалгаан дээрээ үндэслээд дараа нь зөвлөмж гарах уу

Ш.Сэлэнгэ: Та бүхнээс авсан саналаа үндэслээд албан ёсны дүгнэлт, зөвлөмж гарах юм.

Ш.Цолмон: Монголд гурван талын оролцоотой ганцхан байгууллага гэдэг дээр хэр итгэлтэй байна вэ. Ер нь Ажил олгогч эздийн холбоо, Хариуцлагатай уул уурхай гэх мэтийн гурван талын оролцоотой байгууллагууд бас байдаг байх.

Ш.Сэлэнгэ: ОУИТБС-ийг хэрэгжүүлж байгаа гадаад улсуудад ихэвчлэн 1 л бүтэцтэй байдаг. Харин Монголд ажлын алба, ажлын хэсэг, Үндэсний зөвлөл гэсэн бүтэцтэй байдаг гэдгийг харуулсан. Өөрөөр хэлбэл бусад улстай харьцуулсан.

Б.Баярмаа: Энэ чинь зөвхөн гурван талын оролцоотой гээд байгаа юм бишүү.

Б.Дэлгэрмаа: Гурван талын оролцоотой санаачилга нь ганцхан ил тод байдлын санаачилга байна гэж ойлгогдохоор байна.

Б.Батболд: Манай ОУИТБС-аас явуулж байгаа мэдээлэл нь аль сувгаар түлхүү явуулсан байна гэх мэт төрөлжүүлсэн үү.

Ш.Сэлэнгэ: Энэ асуултын хүрээнд байхгүй. Бид дараагийн төлөвлөгөөгөө гаргахдаа тэр мэдээллийг гаргаж ашиглана.

Б.Бямбадагва: Энэ төрлийн судалгааны үр дүн нь Үндэсний зөвлөлд танилцуулагдах уу. Ямар үр дүн гарч ямар зөвлөмж өгөх вэ? Судалгааг харахад зөвхөн ажлын хэсгээс авсан судалгаа явж байна. Үндэсний зөвлөлтэйгээ муу

ажилладаг гэсэн тодорхой санал, шүүмжлэлүүд байна гэж гарлаа үүнийгээ Цаашдаа бүтэц бүрэлдхүүнийг дээд түвшиндээ тавих уу.

Ш.Сэлэнгэ: Бидний хувьд бол тийм юм байхгүй. Цаашдаа хаана яаж таницуулах нь ажлын хэсэг мэдэх байх.

Н.Алгаа: Дараагийн асуудлыг дараа нь ярья. Одоо яг энэ судалгаатай холбоотой тодруулах юмаа асууна уу.

Ж.Энхжаргал: Энэ ажлын эцэст хоёр том хурал болно. Үүнд нэгдүгээрт стратегиа таницуулна. Түүнд Үндэсний зөвлөлийнхөн уригдана. Маш товчхон хийнэ. Тэгээд та бүхнээс дахин санал аваад эцсийн стратегиа боловсруулна.

Н.Алгаа: Энэ судалгааны захиалагч нь Ажлын хэсэг, Үндэсний зөвлөл юм. Хамгийн гол нь бид коммуникация сайжруулах гэх зорьсон. Эцэст нь нэгдсэн зөвлөмж гарсаны дараа бид хэлэлцээд өөрсдийн ажлаа л сайжруулах зорилготой юм. Голдуу ажлын хэсэг рүү чиглэсэн зөвлөмж гарах байх. Бид түүний дагуу төлөвлөгөөгөө боловсруулаад Үндэсний зөвлөлөөр батлуулаад ажиллах ёстой байх. Ингээд та бүхэн хоёр судалгааг нийлүүлээд саналаа хэлвэл сайн байна.

Ш.Цолмон: Энэ судалгаа нь манай ажлын гол хэсэг бөгөөд Европын сэргээн босголт банкны санхүүжилтээр хийгдэж байгаа юм. Бидний 2010 оноос хойш хийх гэж оролдоод байгаа ажил бөгөөд үүний маань юу нь болохгүй байна, цаашдаа яах хэрэгтэй байна зэрэг асуудлыг тодорхойлохоор хийгдэж байгаа юм. Судалгааны хувьд зарим нэг зүйлтэй санал нийлэхэд хэцүү байгаа. Хоёрдугаар хэсгийн судалгаа нь ерөнхийдөө мэдээллийг боловсруулж чадахгүй байна, хүн хүч дутуу, хөрөнгө санхүү муу гэх мэтчилэн байдаг л дүгнэлт гарсан юм шиг санагдаж байна. Бид арай өөр юм олж харах болов уу гэж бодож байлаа. Харин бидний сэтгэлгээнд байна уу, эсвэл асуудал маань томдоод байна уу гэх мэтээр дүгнэлтэн дээрээ эргэж харвал яасан юм гэж бодож байна.

Н.Алгаа: Миний бодлоор энэ судалгааг муу хийгдсэн гэж үзэхгүй байна. Бидэнд хэрэгтэй байгаа зүйлүүдийг тодорхойлсон байна. Өнөөдрийг хүртэл бид зорилго, алсын хараа гэх мэтийг тодорхой болгоогүй байна. Тэгэхээр бид эндээс ажлаа эхлэх ёстой. Мөн мэдээлэл боловсруулах гэдэг дээр бид ямар мэдээлэл хэнд хэрэгтэй вэ гэдэг зорилгоо тодорхойлж чадаагүй учраас мэдээллээ боловсруулж чадахгүй байна. Бид маш их цаастай боловч түүнийгээ ашиглан мэдээллээ түгээж чадахгүй байна. Иймээс бид үндсэн зорилгодоо хүрч чадахгүй байгаа юм. Энэ дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн эрхэм зорилго, алсын хараагаа тодорхой болгох нь хамгийн чухал юм. Иймээс судалгааны багаас шаардлагатай гол асуудлуудыг тодорхой болгоод өгвөл сайн байна.

П.Оюунбилэг: Төслийн хүрээнд хамгийн эцсийн семинар зохион байгуулах ёстой. Тэр семинар дээрээ энэ 13 зорилгоосоо хамгийн гол гурван асуудлыг тодорхойлох боломжтой юм.

Ш.Сэлэнгэ: Бид бол коммуникацийн асуудал гэрээлсэн учраас хязгаарлагдмал байгаа. Зорилго тодорхойлох бол уг нь өөр ажил юм. Гэхдээ бид аль болохоор хүрч ажиллахыг зорино.

Н.Алгаа: Адам Смитээс хүсэхэд дараагийн удаа цуглаад дугуй ширээний ярилцлага хийгээд эрхэм зорилго, зорилтот бүлгүүдэд ямар мэдээлэл хэрэгтэй

байна гэдгийг тодорхойлох, нийтэд чиглэсэн ямар мэдээлэл түгээх вэ гэдгийг энэ судалгаан дээр үндэслээд гаргаж ирэх хэрэгтэй байна. Түүний дараа тэр мэдээллээ ямар сувгаар хүргэх вэ гэдгийг ярилцах нь зүйтэй байх.

Б.Баярмаа: Судалгаа бол ярилцлагын аргаар хийгдсэн байна. Судалгааны дараа нэгдсэн дүгнэлт зөвлөмж өгөх байх. Энэ судалгаа нь агуулга байхгүй байна. Агуулгын талаас зөвлөмж өгвөл сайн байна. Өөрөөр хэлбэл ямар үг хэллэг хэрэглэх вэ, цаашилбал ямар мэдээллийн хэрэгслээр хийх вэ гэдгийг мэргэжлийн байгууллагын хувьд тодорхойлж өгвөл сайн байх.

Н.Алгаа: Коммуникаци бол маш том асуудал тусгай эзэмшсэн мэргэжлийн хүн хийх ёстой ажил юм. Бид боломжтой бол төсөв мөнгөө батлуулаад тусгай мэргэжлийн багийг ажлуулаад яг тэр байгууллагуудаар хүмүүст мэдээллээ хүргүүлэх хэрэгтэй юм. Ажлын алба бол маш их ажилтай, үүнийг хийж барахгүй. Ямар мэдээлэл яаж хүргэх вэ гэдгийг мэргэжлийн байгууллага зөв тодорхойлж хүргэдэг. Иймээс ажлын хэсэг зорилго, зорилтот бүлгээ зөв тодорхойлоход судалгааны байгууллагын хийсэн ажлын гол нь байх ёстой. Яагаад гэвэл бид мэргэжлийн хүнээр юмаа хийлгэж сурах хэрэгтэй байна.

Ш.Цолмон: Ил тод байдлыг идэвхжүүлэх гол ажил нь коммуникаци юм. Маш их олон мэдээлэл байгаа боловч тэрнээс алийг илүү ашиглах хэрэгтэй гэдэг талаар гаргах нь чухал болов уу. Судалгаа нь арай нарийн мэргэшээд байна уу.

Н.Алгаа: Мэдээлэл маш их байна. Бид ямар мэдээллийг хүргэх вэ гэдгээ л сайн тодорхой болгох хэрэгтэй байна. Иргэдэд ямар мэдээлэл хэрэгтэй байна, компанид ямар мэдээлэл хэрэгтэй байна гэдгээ тодорхойлоод дараа нь ямар мэдээллийн хэрэгслээр тараах вэ гэдгээ л шийдэх хэрэгтэй юм. Гадаад орнуудын янз бүр туршлага санаанууд байна. мэдээллийг багцлаад хүний нүдэнд шууд харагдах байдлаар хүмүүст түгээх хэрэгтэй байх.

Ш.Сэлэнгэ: Бидний зөвлөмж нь төлөвлөгөө гаргана. Тэр нь 5 хэсгээс бүрдэнэ. Үүнд: эрхэм зорилго, коммуникацийн зорилго, ямар бүлгүүдэд, ямар хэрэгслээр, төсөв санхүү гэсэн чиглэлийн дагуу гарна.

Н.Алгаа: Бид дүгнэлт зөвлөмжийг гарсны дараа дахин өөр туслалцаа авах хэрэгтэй байвал чадавхийг хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэх ч юм уу дахин холбогдох боломжтой байх.

Ш.Сэлэнгэ: Бид мэдээлэл түгээх тал дээр ялангуяа хэвлэл мэдээлэл дээр нилээд туслах бодолтой байгаа. Холбогдох нөлөө бүхий хүмүүстэй уулзуулж холбож өгөхийг зорьж байна.

Ж.Гомбожав: Би түрүүний судалгааны уулзалт дээр тодорхой дөрвөн төрлийн санал тавьсан байгаа. Судалгааг харахад олон нийтэд хүрэх тал дээр муу үнэлгээ авсан байна. Иргэд яг өөрт хэрэгтэй мэдээллээ л сонирхож байгаа. Бидэнд мэдээлэл тайлан энэ тэр хийж байгаа ажил их байгаа юм байна. Үүнийгээ ашиглан хэнд яаж хүргэх талаар л арга хэмжээ боловсруулах хэрэгтэй. Мэдээллийн сувгууд нь голдуу улс төрийн бүлэглэлийн эрх ашгийн төлөө байгаа учраас хүчинд автаагүй мэдээллийг хүргэх өөрийн сувагтай болоход анхаараач гэсэн саналтай байна. Судалгааны үр дүн, зөвлөмжид үндэслэн хэнд ямар мэдээлэл хэрэгтэй байна гэдгээ л зөв тодорхойлж, хүргэх хэрэгтэй байна.

Ж.Энхжаргал: Өнөөдөр бид чухал үнэтэй санал авлаа. Үүнийг ажилдаа тусгах болно. Бид стратегийн чиглэлээр зөвлөгөө өгдөг компани юм. Бидний ажлын 30 хувь нь судалгаа, 70 хувь нь дүгнэлт байх ёстой. Гэтэл энэ ажил маань судалгаа хийгдээгүй байсан учир одоо бидний хийсэн юмны 50 хувь нь судалгаа болоод байгаа юм. Үүнээс хойш стратеги боловсруулах болно. Дараагийн удаа бид сургалт, семинар хийх болно. Үүгээрээ та бүхэнтэй санал солилцох тул идэвхтэй оролцоорой.

Н.Алгаа: Одоо асуудал дууссан тул шийдвэрийн төслөө ярилцая.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Ажлын хэсгийн гишүүдийн санал дүгнэлтийг тусгаад, судалгааг сайшаав.

Ажлын хэсгийн хурал 12 цагт 30 минутад өндөрлөв.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн
гүйцэтгэх захирал

Н.Алгаа

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга,
ажлын албаны зохицуулагч

Ш.Цолмон

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Ажлын албаны санхүүгийн
мэргэжилтэн

А.Отгонтунгалаг